



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 03 сарын 09 өдөр

Дугаар

A/59

Мандалговь

“Төсөв төсөл” ХХК-тай гэрээ байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь заалт, аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/27 тоот захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн “Зураг төсөв боловсруулах” ажлын зардлаас “Аймгийн ЗДТГ-ын “E-Mongolia” төрийн үйлчилгээний цэгийн тохижилт, баруун, зүүн коридорын засварын ажлын зураг төсөв боловсруулах” ажлыг 10,000,000 (арван сая) төгрөгөөр гүйцэтгэхээр ирүүлсэн үнийн саналаар “Төсөв төсөл” ХХК-тай 10,000,000 (арван сая) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2.Батлагдсан зургийн даалгаврын дагуу “Аймгийн ЗДТГ-ын “E-Mongolia” төрийн үйлчилгээний цэгийн тохижилт, баруун, зүүн коридорын засварын ажлын зураг төсөв боловсруулах” ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Төсөв төсөл” ХХК-ийн захирал (Х.Батбаатар)-т үүрэг болгосугай.

3.Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ДОРЖБАТ

4822150124